



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/14-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Хүдэр сум
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас: 70363040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 70363036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn
Ахлах аудитор : Ц.Отгонбаяр
Утас: 70362442 Цахим хаяг:
Otgonbayarts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....
4. Аудитын тайлан.....
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АТӨЯХАТ	Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ХҮДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГА
Г.ЭНХТҮВШИН ТАНАА

2023-03-25 № СЭА-2023/М-НА-СТА-ТТЗ

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Хүдэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүдэр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хүдэр сумын ТТЗ нь 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 90.7 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 9.3 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

ЕБС, цэцэрлэг болон эрүүл мэндийн байгууллагуудыг улсын төсвийн байгууллага болгосонтой холбоотойгоор ТТЗ-ийн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл буурсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд танилцуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

СЭА-2023/14-НА-СТА-ТТЗ

4

- 018020386

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,040,098.4	3,032,681.5
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,641,266.9	2,797,651.6
33	АВЛАГА	206,228.98	165,151.8
35	БАРАА МАТЕРИАЛ	192,602.5	69,878.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,628,899.6	3,291,236.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,628,899.6	3,291,236.6
39200	Биет хөрөнгө	6,571,839.1	3,265,478.8
39300	Биет бус хөрөнгө	57,060.5	25,757.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,668,998.0	6,323,918.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,459.0	6,250.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,459.0	6,250.4
41300	Өглөг	8,459.0	6,250.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,667,872.6	6,317,667.6
51	Засгийн газрын хувь оролцоо	8,667,872.6	6,317,667.6
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,019,840.1	287,430.8
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		287,430.8
51200	Хуримтлагдсан үр дүн	4,278,623.7	5,622,444.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,362,075.2	407,792.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,668,998.0	6,323,918.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,536,595.7	4,414,784.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,973,875.2	3,203,514.2
110	Орлогын албан татвар	44,939.2	378,248.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	44,939.2	378,248.4
113	Хөрөнгийн албан татвар	35,287.4	41,162.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,893,648.6	2,784,103.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,361,313.2	745,176.3
120	Нийтлэг татварын бус орлого	1,361,313.2	745,176.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,191,478.3	466,093.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,354,980.7	1,991,822.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,155,447.6	1,686,830.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,020,859.3	1,382,799.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,608,079.9	437,629.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	214,602.9	54,040.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	285,618.9	296,164.5
2104	Хангамж, бараа материалын зардал	74,382.9	27,298.1
2105	Нормативт зардал	200,674.0	355.1

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,624.9	20,686.8
2107	Томилолт, зочны зардал	4,949.1	4,675.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,436.2	56,358.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	553,490.6	485,591.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	134,588.2	304,031.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	199,533.2	304,991.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,171,685.9	2,422,961.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	433,701.2	4,750,500.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,737,984.8	-2,327,538.4

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,929,887.8	0.0	6,929,887.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,929,887.8	0.0	6,929,887.8
9	Тайлант үеийн үр дүн	1,730,651.2	0.0	1,730,651.2
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,660,539.0	0.0	8,660,539.0
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,660,539.0	0.0	8,660,539.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-49,292.6	0.0	-49,292.6
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,611,246.4	0.0	8,611,246.4
19	Тайлант үеийн үр дүн	-2,327,538.4	0.0	-2,327,538.4
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,317,667.6	0.0	6,317,667.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,541,426.0	4,089,374.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	1,973,875.2	3,203,514.2
110	Орлогын албан татвар	44,939.2	378,248.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	44,939.2	378,248.4
113	Хөрөнгийн албан татвар	35,287.4	41,162.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	1,893,648.6	2,784,103.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	78,168.5	145,529.0
1181	Газрын төлбөр	109,135.0	287,309.1
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	1,706,345.1	2,351,265.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	370,814.6	423,554.8
120	Нийтлэг татварын бус орлого	370,814.6	423,554.8

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,190,595.3	462,305.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,745,601.2	1,485,037.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,745,601.2	1,485,037.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,610,922.8	1,174,729.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,605,560.8	436,973.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	214,890.5	54,040.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	294,618.9	296,164.5
2104	Хангамж, бараа материалын зардал	72,142.0	27,298.1
2105	Нормативт зардал	169,188.2	355.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,588.3	49,836.6
2107	Томилолт, зочны зардал	4,949.1	4,675.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,194.9	67,141.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	166,790.1	238,244.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	134,678.4	310,307.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,789,683.8	2,604,337.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	846,809.2	1,447,953.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	846,809.2	1,447,953.0
2200	Дотоод эх үүсвэрээр	846,809.2	1,447,953.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-846,809.2	-1,447,953.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	71,000.0	
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	871,874.6	1,156,384.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	769,392.4	1,641,266.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,641,266.9	2,797,651.6

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,763,156.50	2,506,875.40	256,281.10	90.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,268,125.40	1,207,308.60	60,816.80	95.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,230,417.20	1,169,611.90	60,805.30	95.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	439,796.60	435,237.10	4,559.50	98.96
210101	Үндсэн цалин	264,498.10	264,108.10	390.00	99.85
210102	Нэмэгдэл	79,235.30	82,242.30	-3,007.00	103.80

210104	Урамшуулал	86152.4	81590.8	2,614.90	73.62
210105	Гэрээт ажлын хөлс	9,910.80	7,295.90	2,083.50	96.29
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,124.20	54,040.70	1,482.30	96.11
210201	Тэтгэврийн даатгал	38,124.70	36,642.40	168.80	96.25
210202	Тэтгэмжийн даатгал	4,500.00	4,331.20	194.70	94.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,391.60	3,196.90	-161.90	114.62
210204	Ажилгүйдлийн даатгал	1,107.50	1,269.40	399.70	95.56
210205	Эрүүл мэндийн даатгал	9,000.40	8,600.70	33,420.40	89.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	329,584.90	296,164.50	18,416.60	56.86
210301	Гэрэл, цахилгаан	42,687.70	24,271.10	15,003.80	94.09
210302	Түлш, халаалт	253,730.60	238,726.80	0.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	33,166.60	33,166.60	2,256.90	91.78
2104	Хангамж, бараа материалын зардал	27,461.10	25,204.20	38.90	99.68
210401	Бичиг хэрэг	3667.2	5365.3	2.20	99.89
210402	Тээвэр, шатахуун	12,003.80	11,964.90	3,911.60	34.81
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,023.80	2,021.60	2.40	99.94
210404	Ном, хэвлэл	6,000.00	2,088.40	2.40	99.94
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,766.30	3,763.90	8,603.90	86.69
2105	Нормативт зардал	465.30	355.10	0.00	#DIV/0!
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	465.30	355.10	38.60	99.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	64,652.50	56,048.60	950.10	36.66
210601	Багаж, техник, хэрэгсэл	38,638.60	38,600.00	572.20	0.00
210602	Тавилга	1,500.00	549.90	950.10	36.66
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	572.20	0.00	572.20	0.00
210604	Урсгал засвар	23,941.70	16,898.70	7,043.00	70.58
2107	Томилолт, зочны зардал	4,877.40	4,675.60	201.80	95.86
210702	Дотоод албан томилолт	4,877.40	4,675.60	201.80	95.86
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	68,091.00	66,841.60	1,249.40	98.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	68,145.70	66,525.70	1,620.00	97.62
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	189.90		189.90	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	304.70	243.50	61.20	79.91
210804	Тээврийн хэрэгслийн татвар	195.60		195.60	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	89.10	61.40	27.70	68.91
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	104.70		104.70	0.00
210807	Газрын төлбөр	4.80		4.80	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	8.10		8.10	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	48.40		48.40	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	238,364.20	231,044.50	7,319.70	96.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	238,351.10	231,044.50	7,306.60	96.93
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13.10	0.00	13.10	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,708.20	37,696.60	11.60	99.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,708.20	37,696.60	11.60	99.97
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,196.60	33,196.60	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,511.60	4,500.00	11.60	99.74
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,420,031.10	1,299,566.80	120,464.30	91.52
220001	Барилга байгууламж	1,260,031.10	1,194,027.40	66,003.70	94.76
221001	Их засвар	160,000.00	105,539.40	54,460.60	65.96

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	75,000.00		75,000.00	0.00
230001	Эргэж төлөгдөх зээл	75,000.00		75,000.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,763,156.50	2,717,183.00	45,973.50	98.34
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,627,156.50	2,512,530.20	114,626.30	95.64
320001	Орон нутгийн төсвөөс	2,320,817.40	2,206,191.10	114,626.30	95.06
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	306,339.10	306,339.10	0.00	100.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	136,000.00	204,652.80	-68,652.80	150.48
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	66,000.00	30,452.80	35,547.20	46.14
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		174,200.00		
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	70,000.00		70,000.00	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	159,754.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	21,368.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,117.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,736.00
210104	Урамшуулал	1,736.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,093.80
210401	Бичиг хэрэг	735.00
210402	Тээвэр, шатахуун	1,328.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,788.00
210604	Урсгал засвар	3,788.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,250.40
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,250.40
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	6,250.40
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	138,386.20
2200	Дотоод эх үүсвэрээр	138,386.20
220001	Барилга байгууламж	138,386.20
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	159,754.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	159,754.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,514.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	147,716.60
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,523.00

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүдэр сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Газар тариалан мал аж ахуйг тэргүүлэх салбараа болгож, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, уул уурхайгаа түшиглэн, аялал жуулчлалыг хөгжүүлж, байгалийн баялгийг зүй зохистой ашиглан өрхийн үйлдвэрлэлээ дэмжиж, хүн амынхаа амар тайван, элбэг хангалуун амьдрах нөхцөлийг бүрдүүлэх” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,*
- *Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Тайлант онд дотоод хяналт, шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүдэр сумын ТТЗ нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хүдэр сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүдэр сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,352,413.6 мянган төгрөгөөр буюу 27.1хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,641,266.90	2,797,651.60	1,156,384.70
Авлага	206,229.00	165,151.80	(41,077.20)
Бараа материал	192,602.50	69,878.10	(122,724.40)
Үндсэн хөрөнгө	6,636,233.20	3,291,236.50	(3,344,996.70)
Нийт хөрөнгө	8,676,331.60	6,323,918.00	(2,352,413.60)
Өр төлбөр	8,459.00	6,250.40	(2,208.60)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,667,872.60	6,317,667.60	(2,350,205.00)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,676,331.60	6,323,918.00	(2,352,413.60)

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансад бөгөөд өөрчлөлтийг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 2,797,651.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,156,384.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө			
Төрийн сангийн харилцах	1,641,266.9	2,797,651.6	1,156,384.7
Нэмэлт санхүүжилтийн харилцах			
Дүн	1,641,266.9	2,797,651.6	1,156,384.7

Эх сурвалж: Хүдэр сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд тайлагнагдсан орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 2,510,236.8 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 243,050.1 мянган төгрөг, нөхөн сэргээлтийн барьцаа хөрөнгийн үлдэгдэл 1,000.0 мянган төгрөг, Хоршоог хөгжүүлэх сангийн үлдэгдэл 43,364.7 мянган төгрөг тус тус байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 165,151.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 41,077.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	9,813.10	9,813.10	-
Зээлийн хүүгийн авлага	7,652.10	7,752.10	100.00
Байгууллагаас авах авлага	26,868.30	19,641.50	(7,226.80)
Хувь хүмүүсээс авах авлага	6,699.50		(6,699.50)
Хувь хүмүүст олгосон зээл	155,196.00	127,945.00	(27,251.00)
Дүн	206,229.00	165,151.70	(41,077.30)

Эх сурвалж: Хүдэр сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэлд ЗДТГ-ын 28,127.5 мянган төгрөг, хоршоог хөгжүүлэх сангийн 135,697.1 мянган төгрөг, Орон нутгийн ерөнхий орлогын 1,327.1 мянган төгрөгийн авлагууд бүртгэлтэй байна.

Тайлант оны нийт авлагын эцсийн үлдэгдлийн 82.2 хувь буюу 135,697.1 мянган төгрөгийг Хоршоог хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн авлага эзэлж байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 69,878.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 122,724.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Эм боох материал	30,772.80		(30,772.80)
Бичиг хэргийн материал	2,000.90	24,223.50	22,222.60
Аж ахуйн материал	82,939.40	13,824.50	(69,114.90)
Сэлбэг хэрэгсэл	5,900.50		(5,900.50)
Хүнсний материал	1,361.80		(1,361.80)
Бусад хангамжийн материал	68,967.10	31,170.10	(37,797.00)
Мал амьтад	660.00	660.00	-
Дүн	192,602.50	69,878.10	(122,724.40)

Эх сурвалж: Хүдэр сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТТЗ-ийн бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оны үлдэгдлээс 122,724.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 267,050.1 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн, 222,225.1 мянган төгрөгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хөрөнгийг орлого авсан зэргээр нийт 489,275.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, 230,736.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 222,225.1 мянган төгрөгийн орон нутгийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлыг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгч, сургууль, цэцэрлэг, өрхийн эрүүл мэндийн төвүүд тус тусын яамдын төсвийн ерөнхийлөн захирагчид харьяалагдах болж, 159,037.9 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- ЗДТГ нь 4,520.5 мянган төгрөг, ИТХ нь 2,950.0 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивээгүй болон бөөн дүнгээр шивсэн,
- ЗДТГ нь тайлант онд худалдан авсан 3,993.8 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, хүнсний материал, барилгын засварын материалыг ангиллын дагуу бус бусад хангамжийн материалд бүртгэн тайлагнасан.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 3,291,236.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 3,337,663.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	6,571,839.10	3,265,478.90	(3,306,360.20)
Барилга, байгууламж, орон сууц	4,654,143.30	784,481.20	(3,869,662.10)
Авто-тээврийн хэрэгсэл	135,255.00	367,145.40	231,890.40
Машин тоног төхөөрөмж(компьютер)	237,465.80	110,467.10	(126,998.70)
Тавилга, аж ахуйн эд хогшил	136,004.80	21,794.40	(114,210.40)
Зам гүүрийн байгууламж	681,961.20	1,102,033.60	420,072.40
Дуусаагүй барилга	27,431.30	27,431.30	-
Номын фонд	33,013.10	-	(33,013.10)
Түүх соёлын дурсгалт зүйл	250.00	250.00	-
Бусад үндсэн хөрөнгө	666,314.60	851,875.90	185,561.30
Биет бус хөрөнгө	57,060.50	25,757.70	(31,302.80)
Программ хангамж	509.70	455.70	(54.00)
Бусад биет бус хөрөнгө	56,550.80	25,302.00	(31,248.80)
Дүн	6,628,899.60	3,291,236.60	(3,337,663.00)

Эх сурвалж: Хүдэр сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос /анхны өртгөөр/ 3,658,144.3 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 148,386.2 мянган төгрөгийн худалдан авалт хийж, 317,333.7 мянган төгрөгийн хөрөнгийг ОНХС-ийн эх үүсвэрээс бэлтгэж, 710,977.3 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авсан зэргээр нийт 1,176,697.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, 4,834,841.5 мянган төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр холбогдох ерөнхийлөн захирагчдад шилжүүлснээс голлон шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

- ИТХ нь 9,450.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг нэр төрлөөр нь бус бөөн дүнгээр орлого авч бүртгэлд тусгасан,

- ЗДТГ нь тайлант онд худалдан авсан 9,217.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг тогтоогоогүйгээс элэгдлийн зардлыг дутуу илэрхийлсэн,

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 6,250.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,208.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	3,745.60		(3,745.60)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	734.70		(734.70)
Байгууллагад төлөх өглөг	3,978.70	6,250.40	2,271.70
Дүн	8,459.00	6,250.40	(2,208.60)

Эх сурвалж: Хүдэр сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн дансны үлдэгдэлд ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг ОНЕО-ын дансанд төвлөрүүлснээс үүссэн 6,250.4 мянган төгрөгийн өглөг тайлагнагдсан байна.,

Аудитын илрүүлэлт:

- Төлбөр тооцоог хянаагүйгээс ЗДТГ нь 4,030.4 мянган төгрөгийн, ИТХ нь 5,052.5 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг үүсгэж, санхүүгийн тайланд тусгаагүй байна,

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 6,317,667.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,342,871.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,019,840.10	287,430.80	(732,409.30)
Хуримтлагдсан үр дүн	4,278,623.70	5,622,444.40	1,343,820.70
Өмнөх үеийн үр дүн	2,547,972.60	7,949,982.80	5,402,010.20
Тайлант үеийн үр дүн	1,730,651.10	(2,327,538.40)	(4,058,189.50)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,362,075.20	407,792.40	(2,954,282.80)
Дүн	8,660,539.00	6,317,667.60	(2,342,871.40)

Эх сурвалж: Хүдэр сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,342,871.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалсан байна.

3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой **26,737.5** мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагч:

1. Сумын ОНХО-аар хэрэгжсэн 2 төсөл, арга, хэмжээний гүйцэтгэгчид 6,324.5 мянган төгрөгийн санхүүжилтийг илүү тооцож олгосон ,
2. Засаг даргын нөөц хөрөнгөөс хилийн зурвас, бүсэд самар түүж байгаа иргэдийн хөдөлгөөнд хяналт тавих шатахууны зардалд 3,000.0 мянган төгрөгийг Хилийн цэргийн 0246 дугаар ангийн нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн боловч зарцуулалтыг нотлох анхан шатны гүйцэтгэлийн баримт материалыг бүрдүүлээгүй.

Засаг даргын тамгын газар:

1. “Суваг Ти Ви найм “ телевизтэй гэрээ байгуулж “Монголоороо аялцгаая” нэвтрүүлэг бэлтгэхэд 2,500.0 мянган төгрөг, сумын 50 жилийн түүхт ойтой холбоотой танилцуулга хийлгэхэд 1,350.0 мянган төгрөг тус тус зарцуулсан,
2. Батлагдсан төсвийг зардлын бүлэг хооронд гүйлгэн нийт 6,690.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,
3. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас байгаль хамгаалагч нарт 1,650.0 мянган төгрөгийн нормын хувцас худалдан авч зориулалт бусаар зарцуулсан,
4. Өмч хамгаалах зөвлөлөөр эвдрэл, гэмтлийг тогтоогоогүй буюу техникийн комиссын акт, дүгнэлтгүйгээр автомашины засвар үйлчилгээнд 2,713.0 мянган төгрөг зарцуулсан.

Иргэдийн Төлөөлөгчийн хурал:

1. Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Д.Цэцэгсайханд 650.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгосныг суутгаагүй,
2. Нутгийн удирдлагын 30 жилийн ойг тохиолдуулан ном хийлгэхэд 1,000.0 мянган төгрөг, өнгөт хэвлэл хийлгэхэд 550.0 мянган төгрөг зэрэг нийт 1,550.0 мянган төгрөгийг зарцуулсан,
3. Батлагдсан төсвийг зардлын бүлэг хооронд гүйлгэн нийт 310.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Хүдэр сумын ИТХ-ын “2022 оны тодотгосон төсөв батлах тухай” 2022 оны 81 дүгээр тогтоолоор 1,018,204.1 мянган төгрөгийн татварын орлого, 75,000.0 мянган

төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 3,421,416.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөөг 3.1 дахин давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

№	Татварын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	Татварын орлого	1,018,204.10	3,203,514.20	2,185,310.10	314.62
3	Хүн амын орлогын албан татвар	265,280.00	378,248.40	112,968.40	142.58
4	Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого	240,000.00	341,390.10	101,390.10	142.25
6	Үйл ажиллагааны орлого	10,000.00	15,768.30	5,768.30	157.68
7	Хөрөнгө борлуулсны орлого	15,000.00	15,009.20	9.20	100.06
8	Хөрөнгийн орлого/ Хадгаламжийн хүүгийн татварын орлого/	280.00	6,080.80	5,800.80	21.7 дах
9	Хөрөнгийн албан татвар	13,250.00	41,162.30	27,912.30	3.1 дах
10	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	11,000.00	6,199.10	(4,800.90)	56.36
11	Бууны албан татвар	2,250.00	2,970.00	720.00	132.00
12	Малд ноогдуулах албан татвар	-	31,993.20	31,993.20	
13	Барааны хэрэглээ болон хэрэглэх зөвшөөрлийн бусад татвар	30,800.00	145,529.00	114,729.00	4.7 дах
14	Улсын тэмдэгтийн хураамж	30,000.00	139,756.90	109,756.90	4.6 дах
15	Хог хаягдлын хураамжийн орлого	-	648.00	648.00	
16	ТТАМАТөлбөр	800.00	5,124.10	4,324.10	6.4 дах
17	Газрын төлбөр	300,940.40	287,309.10	(13,631.30)	95.47
18	Газрын төлбөр	300,940.40	287,309.10	(13,631.30)	95.47
20	Байгалийн нөөц ашигласны төлбөр	407,933.70	2,351,265.40	1,943,331.70	5.7 дах
21	Ойн нөөц ашигласны төлбөр	204,841.70	246,937.60	42,095.90	120.55
22	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	2,532.00	986.00	(1,546.00)	38.94
23	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	200,560.00	2,103,341.80	1,902,781.80	10.4 дах
29	Татварын бус бусад орлого	75,000.00	217,902.00	142,902.00	2.9 дах
30	нэр заагаагүй бусад орлого	45,000.00	30,076.50	(14,923.50)	66.84
31	Хүү, торгуулийн орлого	30,000.00	187,825.50	157,825.50	6.2 дах
	Нийт дүн	1,093,204.10	3,421,416.20	2,328,212.10	3.1 дах

Эх сурвалж: Хүдэр сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд малын тоо толгойн албан татварыг төлөвлөөгүй боловч гүйцэтгэлээр 31,993.2 мянган төгрөг төвлөрсөн, цалин хөлс, түүнтэй адилтгах орлого 101,390.0 мянган төгрөгөөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 109,756.9 мянган төгрөгөөр, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого 1,902,781.8 мянган төгрөгөөр, хүү, торгуулийн орлого 157,825.5 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Орлогын гүйцэтгэлээр үл хөдлөх хөрөнгийн албан татвар, газрын төлбөр, нэр заагаагүй бусад орлого зэрэг орлогууд тасарсан байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- ✓ **Цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлого:** Засгийн газрын 2022 оны 107, 192, 194 дүгээр тогтоолуудаар төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор цалин хөлс, шагнал, урамшуулал болон түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос суутган тооцох татварын орлого нэмэгдэж,
- ✓ **Малын тоо толгойн албан татвар:** Малын тоо толгойн албан татварыг орлогыг огт төлөвлөөгүйгээс шалтгаалсан,
- ✓ **Улсын тэмдэгтийн хураамж болон байгалийн нөөц ашигласны төлбөр:** БОЯ, Ойн судалгаа хөгжлийн төв, Ойн ангитай хамтран самрын нөөц тогтоох ажлыг зохион байгуулснаар ААН-үүдтэй нэмж гэрээ байгуулж, тэмдэгтийн хураамж болон ойн нөөц ашигласны орлого нэмэгдсэн,
- ✓ **Хүү, торгуулийн орлого:** Самрын нөөц тогтоох ажлыг зохион байгуулснаар Ойн ангийн талбай тусгаарлалтын орлого өссөн байна.

Тасарсан орлогууд:

- ✓ **Газрын төлбөр:** Сумын газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын газрын төлбөр төлөлт хангалтгүй байснаас шалтгаалсан,
- ✓ **Нэр заагдаагүй бусад орлого:** Орлогын төлөвлөгөөг өндөр төлөвлөснөөс шалтгаалж тасарсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 2,820,654.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 38 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 1,133,204.1 мянган төгрөг, урьд оны дансны үлдэгдлээс 1,182,000.0 мянган төгрөг, ОНХС-ийн эхний үлдэгдлээс санхүүжих дүнг 93,000.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 306,339.1 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 66,000.0 мянган төгрөг, нийт 2,780,543.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Аймгийн ИТХ-ын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 55 дугаар тогтоолоор аймгийн 2022 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 81 дүгээр тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 40,000.0 мянган төгрөгөөр бууруулан 1,093,204.1 мянган төгрөгөөр, урьд оны дансны үлдэгдлээс санхүүжих дүнг 278,948.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1,460,948.0 мянган төгрөг, ОНХС-ийн эхний үлдэгдлээс санхүүжих дүнг 93,000.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 306,339.1 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 66,000.0 мянган төгрөг зэрэг нийт **3,019,491.2** мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, **2,753,156.5** мянган төгрөгийг зарцуулж, **266,334.7** мянган төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлэхээр эцэслэн баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн орлогоос 3,421,416.2 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 306,339.1 мянган төгрөг, Дархан төмөрлөгийн үйлдвэрээс ОНХС-д хандивын орлого 174,200.0 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 30,452.8 мянган төгрөг зэрэг нийт **3,932,408.1** мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн, **266,334.7** мянган төгрөгийг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **2,506,875.4** мянган төгрөг буюу 90.7 хувьтай тайлагнагдсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин, НДШ-ийн зардал 6,041.8 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 18,416.6 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 950.1 мянган төгрөгөөр, томилолтын зардал 201.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 1,249.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 7,319.7 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг 11.6 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардал 120,464.3 мянган төгрөг, эргэн төлөгдөх зээл 75,000.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын хөрөнгө оруулалтаар нийт 24 төсөл, арга хэмжээнд 1,020,692.0 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 962,393.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 58,298.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 1 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүйгээс шалтгаалсан байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 8 төсөл, арга хэмжээнд 399,339.1 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 337,672.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 61,666.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь 1 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйгээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 147,716.6 мянган төгрөг, аймгийн ЗДНХ-өөс 7,514.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4,523.0 мянган төгрөг зэрэг нийт **159,754.5** мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Үүнээс урамшууллын зардалд 1,736.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 2,093.8 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 3,788.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 300.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 7,200.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 138,386.2 мянган төгрөг зэрэг нийт СЭА-2023/14-НА-СТА-ТТЗ

153,504.1 мянган төгрөгийн зарцуулж, үлдэгдэл 6,250.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хүдэр сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн техникийн комиссын дүгнэлтийг үндэслэн автомашины засварын зардлыг гаргах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төсвийг зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөх, санхүүгийн тайлангийн тайлбар тодруулгыг иж бүрэн хийж зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Отгонбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хүдэр сумын ТТЗ нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1/72 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт орлогын 7,112,739.3 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 71,129.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд хийгдсэн бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалан ЕБС, цэцэрлэг, Соёлын төв, ЭМТ зэрэг байгууллагуудын санхүүгийн тайлан тус тусын яаманд нэгтгэгдсэн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт орлого болох 4,414,784.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон **44,147.8** мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн “Үүрэг чиглэл өгөх тухай” 01/633 дугаар албан бичгийн хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах, СЭА-2023/14-НА-СТА-ТТЗ

батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, өр авлага үүсгэхгүй ажиллах, засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, ТБОНӨХБАҮХА тухай хууль болон босго үнийн журмыг мөрдөн ажиллах, аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах гэх мэт нийт 18 төрлийн чиглэлийг хүргүүлсэн байна.

Үүнээс Хүдэр сумын ТТЗ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- *Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын батлагдсан төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж ажилласнаар жилийн эцэст батлагдсан төсвийг 9.3 хувиар хэмнэсэн,*
- *Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,*

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй хамаарах 28 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад тус хуулийн заалтуудыг зөрчсөн нийт 6,360.0 мянган төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- ИТХ нь Нутгийн удирдлагын байгууллагын 30 жилийн ойг тохиолдуулан ном хийлгэхэд 1,000.0 мянган төгрөг, өнгөт хэвлэл хийлгэхэд 550.0 мянган төгрөг, мянган төгрөг зэрэг нийт 1,550.0 мянган төгрөгийг зарцуулсан,
- ЗДТГ нь “Суваг Ти Ви найм” телевизтэй гэрээ байгуулж “Монголоороо аялцгаая” нэвтрүүлэг бэлтгэхэд 2,500.0 мянган төгрөг, сумын 50 жилийн түүхт ойтой холбоотой танилцуулга хийлгэхэд 1,350.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Эдгээр нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх “... аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор ... салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх”, 15.1.6 дахь “... шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	155	140	15	-
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	151	121	30	-
3	Засаг даргын Тамгын газар	151	128	23	-
	Нийт дүн	457	389	68	-

ТТЗ-ийн түвшинд нийт давхардсан тоогоор мэдээлбэл зохих 457 мэдээллээс 389 мэдээллийг хугацаанд нь, 68 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль, тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн дараах зардлын зарцуулалт нь Төсвийн тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ. Үүнд:

- Сумын баяр наадмын 70,000.0 мянган төгрөгийн төсвийг ОНХС-ийн төсөвт бус ЗДТГ-ын төсөвт тусган санхүүжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно, 60.3.3: “Үндэсний их баяр наадмаас бусад баяр наадам, ойн арга хэмжээ...” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Баяр наадмын зардлыг ОНХС-ийн төсөвт тусган баталж байх зөвлөмж өгөв.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт болон 10,196.9 мянган төгрөгийн албан шаардлага, 33,386.0 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна. Албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг аудитаар дахин хянахад 73.0 хувийн хэрэгжилттэй байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	925.9	1	925.9	100.0
Албан шаардлага	6	49,867.6	4	10,196.9	67.0
Зөвлөмж	4	123,062.1	3	33,386.0	75.0
Нийт дүн	11	173,855.6	8	44,508.8	72.7

1. Өмнөх аудитаар өгсөн бараа материалын худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулж байх гэсэн зөвлөмжийг орон нутгийн байгууллагууд нь хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан байна.

Шийдвэрлэлт: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2. Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж байх, авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах чиглэлээр өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд зөрчлийг давтан гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ...бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг үндэслэн холбогдох албан тушаалтнуудад **сахилгын шийтгэл ногдуулах** албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг шалгаж амжаагүй тул Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн сэдэвт аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

Тус сумын батлагдсан төсөвтэй холбоотой дараах асуудлуудыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

- Сумын ИТХ-ын төсөвт үндсэн чиг үүрэгт хамааралгүй Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 5,000.0 мянган төгрөгийн төсөв баталсан байгаа нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар

зүйлийн 46.3¹, 46.6² дахь заалт болон Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1998 оны 88/152 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ын 1.5³, 2.7⁴ дахь заалтуудтай нийцэхгүй байна. Сумын ИТХ нь дээрх асуудалтай холбоотой бодлогыг тодорхойлж, тухайн арга хэмжээний зарцуулалтад хяналт тавих чиг үүрэгтэй байгууллага юм. Иймд цаашид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төсвийг холбогдох төсөвт нь тусгаж, батлах шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 22,661.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа⁵ илэрч алдааг цаашид арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв. Үүнд:

ЗДТГ :

- Тайлант онд худалдан авсан 3,993.8 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, хүнсний материал, барилгын засварын материалыг ангиллын дагуу бус бусад хангамжийн материалд бүртгэн тайлагнасан,
- Тайлант онд худалдан авсан 9,217.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг тогтоогоогүйгээс элэгдлийн зардлыг дутуу илэрхийлсэн.

ИТХ :

- Тайлант онд худалдан авсан 9,450.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг нэр төрлөөр нь бус бөөн дүнгээр орлого авч, бүртгэлд тусгасан байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Дээрх алдаануудыг 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулах, үндсэн хөрөнгө, бараа материалын хөдлөл өөрчлөлтийг

¹ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг аймаг, нийслэлийн батлагдсан төсөв дээр нь нэмж олгох замаар төвлөрүүлж, сум, дүүргийн Салбар зөвлөл, гэмт хэргийн нөхцөл байдал, цаашдын төлөвийг харгалзан хуваарилж, зарцуулна.

² Зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах хөрөнгийг зөрчлийн нөхцөл байдал, цаашдын төлөв байдлыг харгалзан асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад тухай бүр тусгаж, зарцуулна.

³ Батлагдсан хуваарийн дагуу аймаг, нийслэлийн төсвөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан сум, дүүргийн төсөвт олгосон хөрөнгийг сум, дүүргийн Зөвлөлийн нэрээр тусгай дансанд төвлөрүүлнэ.

⁴ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан тусгай дансанд төвлөрүүлсэн хөрөнгийг сум, дүүргийн Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар дараах зориулалтаар зарцуулна.

⁵ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

холбогдох стандарт, заавар, журмын дагуу үнэн зөв бүртгэж, бүртгэл тайланд тусгаж байх зөвлөмж өгөв.

Аудитаар нийт **43,290.9** мянган төгрөгийн зөрчил илэрснээс 6,974.5 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 33,603.4 мянган төгрөгийн 6 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2,713.0 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт:

1. Төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас сумын ОНХО-аар хэрэгжсэн ажлын санхүүжилтэд нийт 6,324.5 мянган төгрөгийг гүйцэтгэгчид илүү тооцож олгосон байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

- 200,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Наадмын талбай” ажлын гүйцэтгэгч “Амьд төгөл” ХХК-д гэрээний дүнгээс 3,787.4 мянган төгрөгийн илүү санхүүжилт олгосон,
- 60,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “ЗДТГ-ын хашаа, урд талбайн тохижилт” ажлын гүйцэтгэгч Дөлгөөн хангайн түшиг ХХК-д захиалагчийн хяналтын зардал болон магадалшгүй ажлын 2,537.1 мянган төгрөгийн санхүүжилтийг холбогдох нотлох баримтгүйгээр олгосон.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон санхүүжилтийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Д.Цэцэгсайханд 650.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгоод буцаан суутгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”*, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цалингийн урьдчилгааг буцаан суутгах төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 5,400.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15 дугаар зүйлийн 15.1-дэх *“Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”*, 15.1.4: *“... аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор ... салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай*

холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна. Үүнд:

1. ИТХ нь Нутгийн удирдлагын 30 жилийн ойг тохиолдуулан ном хийлгэхэд 1,000.0 мянган төгрөг, өнгөт хэвлэл хийлгэхэд 550.0 мянган төгрөг зэрэг нийт 1,550.0 мянган төгрөг,
2. ЗДТГ нь “Суваг Ти Ви найм” телевизтэй гэрээ байгуулж “Монголоороо аялцгаая” нэвтрүүлэг бэлтгэхэд 2,500.0 мянган төгрөг, сумын 50 жилийн түүхт ойтой холбоотой танилцуулга хийлгэхэд 1,350.0 мянган төгрөг.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж, төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй зарцуулах албан шаардлага хүргүүлэх.

5.2.2 Засаг даргын нөөц хөрөнгөөс хилийн зурвас, бүсэд самар түүж байгаа иргэдийн хөдөлгөөнд хяналт тавих шатахууны зардалд 3,000.0 мянган төгрөгийг улсын төсөвт Хилийн цэргийн 0246 дугаар ангийн нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн боловч зарцуулалтыг нотлох анхан шатны гүйцэтгэлийн баримт материалыг бүрдүүлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дэх “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 6.3 дахь “*Нөөц хөрөнгийн зарцуулалт, тайлагналтыг тухай шатны Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч хариуцан гүйцэтгэнэ.*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтын тайланг холбогдох байгууллагаас бүрэн авч, бүрдүүлэх албан шаардлага хүргүүлэх.

5.2.3 Бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй нийт **7,470.5 мянган** төгрөгийн / ЗДТГ нь 4,520.5 мянган төгрөг, ИТХ нь 2,950.0 мянган төгрөг / бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивээгүй болон бөөн дүнгээр баталгаажуулсан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй*” гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “*... Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “*Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол*” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэх.

СЭА-2023/14-НА-СТА-ТТЗ

5.2.4 Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйгээс цалингийн зардлыг татварын тайланд дутуу тайлагнаж, ЗДТГ нь 4,030.4 мянган төгрөгийн, ИТХ нь 5,052.5 мянган төгрөгийн зэрэг нийт **9,082.9** мянган төгрөгийн ХХОАТ-ын өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог **хянах**...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 2023 оны 2-р улиралд багтаан цалингийн зардлыг татварын тайланд бүрэн тусгаж, ХХОАТ-ын өглөгийг барагдуулах, цаашид төсвийг зохистой удирдаж өглөг үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

5.2.5 Холбогдох албан тушаалтны шийдвэргүйгээр зардлын бүлэг хооронд гүйлгэн нийт 7,000.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг тус тус зөрчсөн байна. Үүнд:

- ЗДТГ нь урсгал засварын зардлаас баяр наадмын зардалд 4,929.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас пос төхөөрөмж авахад 1,200.0 мянган төгрөг, ном хэвлэлийн зардлаас бэлэг дурсгалын зүйл авахад 561.0 мянган төгрөг зэрэг нийт 6,690.0 мянган төгрөг,
- ИТХ нь нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын батлагдсан төсвөөс төлөөлөгчдийн ар гэрт буцалтгүй тусламж 310.0 мянган төгрөг.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.6 Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас байгууллагын урсгал төсөвт тусган хэрэгжүүлбэл зохих байгаль хамгаалагч нарт 1,650.0 мянган төгрөгийн нормын хувцас худалдан авсан байгаа нь Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.1-д “*Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь, хэмжээний доод хязгаартай тэнцэх төлбөрийн орлогын хэсгийг тухайн ашигласан нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулна.*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1.1 Илрүүлэлт: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулагдах зардлыг Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын хавсралтад заасан зардлын ангилал нэр төрлөөр бус бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж зардалд бөөнөөр нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлыг бүлэг, зүйлээр төлөвлөж, хянах зарчмыг алдагдуулж байна.

1.1.2 Өгсөн зөвлөмж: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төсвийг зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж байх.

2.Зардлын данстай холбоотой асуудал

2.1.1 Илрүүлэлт: ЗДТГ нь өмч хамгаалах зөвлөлөөр эвдрэл, гэмтлийг тогтоогоогүй буюу техникийн комиссын акт, дүгнэлтгүйгээр автомашины засвар үйлчилгээнд 2,713.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

2.1.2 Өгсөн зөвлөмж: Техникийн комиссын дүгнэлтийг үндэслэн автомашины засварын зардлыг гаргаж байх.

3. Нягтлан бодох бүртгэл хөтлөлтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Орон нутгийн байгууллагууд нь санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дахь “*Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна*”, 8.1.5 дахь “*санхүүгийн тайлангийн тодруулга*” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Өгсөн зөвлөмж: Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, онцлог байдлыг илтгэсэн тайлбар, тодруулгуудыг хийж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	2	13,211.6			2	13,211.6			2	13,211.6	2	13,211.6
ИТХ	1	9,450.1			1	9,450.1			1	9,450.1	1	9,450.1
Дүн	3	22,661.7			3	22,661.7			3	22,661.7	3	22,661.7

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	2		1	6,324.5	1	3,000.0						
ЗДТГ	5				3	20,740.9	2	2,713.0				
ИТХ	4		1	650.0	2	9,862.5	1					
Дүн	11	43,290.9	2	6,974.5	6	33,603.4	3	2,713.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ТТЗ	1	70,000.0					1	70,000.0
Дүн								
Нийт дүн	1	70,000.0					1	70,000.0